



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/81/НА-СБА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт хот 2022 он	Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: М.Нарантуяа  Утас: 70518369 Цахим хаяг: <a href="mailto:narantuyam@audit.gov.mn">narantuyam@audit.gov.mn</a> Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: <a href="mailto:davaag@audit.gov.mn">davaag@audit.gov.mn</a> Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512127 Цахим хаяг: <a href="mailto:barchidgunseno@audit.gov.mn">barchidgunseno@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Төлбөрийн акт.....	15
4.2 Албан шаардлага .....	16
4.3 Зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518398, Факс: 70518398  
E-mail: Sukhbatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Н.УЛААНХҮҮХЭН ТАНАА

2022.02.25 № 7д  
тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Халзан сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ковид-19 цар тахлын хүрээнд иргэдэд төлбөртэй шинжилгээ хийж төлбөрийг байгууллагын харилцах дансанд төвлөрүүлээгүй, эмч, эмнэлгийн ажилчдын илүү цагийн хөлсийг анхан шатны баримтын бүрдэл дутуу маягаар олгосон, эргэлтийн эмийн сангаас худалдан авсан эмийг бараа материалын тайланд бүртгээгүй, хөрөнгө бараа материалын үлдэгдэлд тооллогыг чанаргүй хийсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,900,076.51</b>	<b>217,101,702.55</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	38,624,126.27
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	38,624,126.27
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	38,624,126.27
31211	Төрийн сангийн харилцах	00.00	12,215,705.39
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	26,408,420.88
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	450,000.00	117,736,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	450,000.00	117,736,000.00
3351	Байгууллагаас авах авлага	450,000.00	117,736,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	52,450,076.51	60,741,576.28
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	25,180,845.97	14,310,507.75
35110	Тусгай зориулалттай материал	16,887,845.00	10,549,664.78
35130	Эм боох материал	8,293,000.97	3,760,842.97
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,829,230.54	41,421,068.53
35410	Бичиг хэргийн материал	2,502,915.00	2,861,840.00
35420	Аж ахуйн материал	9,270,434.00	9,481,434.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,666,500.00	3,606,700.00
35440	Түлш, шатах тослох материал	881,808.00	539,648.45
35450	Барилгын засварын материал	00.00	20,367,000.60
35460	Хүнсний материал	1,593,123.54	2,545,495.48
35470	Бусад хангамжийн материал	1,914,450.00	2,018,950.00
35600	Мал амьтад	5,440,000.00	5,010,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>306,293,638.43</b>	<b>361,940,816.74</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	306,293,638.43	361,940,816.74
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	298,265,638.43	353,912,816.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,954,935.65	298,954,935.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,846,062.22	-56,110,299.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,736,434.00	31,736,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,784,883.74	-21,740,956.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,957,499.82	135,670,459.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,210,435.63	-58,171,689.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,384,771.00	29,952,874.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,866,620.65	-16,478,941.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,550,000.00	16,550,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,609,999.80	-6,449,999.80
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,028,000.00	8,028,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,028,000.00	8,028,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>359,193,714.94</b>	<b>579,042,519.29</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>359,193,714.94</b>	<b>579,042,519.29</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	359,193,714.94	579,042,519.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	285,892,103.87	285,892,103.87
51101	Өмч: - төрийн	285,892,103.87	285,892,103.87
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-82,442,953.12	137,405,851.23
51210	Өмнөх үеийн үр дүн	-82,442,953.12	-82,442,953.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	219,848,804.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	155,744,564.19	155,744,564.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>359,193,714.94</b>	<b>579,042,519.29</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>395,940,558.00</b>	<b>812,852,364.39</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,251,097.00</b>	<b>69,766,918.39</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,251,097.00	69,766,918.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,251,097.00	69,766,918.39
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,251,097.00	69,766,918.39
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>41,096,461.00</b>	<b>381,747,446.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	337,593,000.00	361,338,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,127,181.00	351,913,124.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,983,681.00	351,073,124.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	143,500.00	840,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	14,244,000.00	17,370,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,244,000.00	17,370,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	14,725,280.00	12,464,022.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,725,280.00	12,464,022.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>389,553,843.48</b>	<b>593,003,560.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>389,553,843.48</b>	<b>593,003,560.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	361,964,887.30	562,420,246.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,619,063.31	331,402,245.41
210101	Үндсэн цалин	168,549,792.96	227,048,962.56
210102	Нэмэгдэл	51,529,021.41	73,961,780.62
210104	Урамшуулал	20,540,248.94	30,391,502.23
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,014,161.91	36,004,681.32
210201	Тэтгэврийн даатгал	23,735,199.43	25,366,990.35
210202	Тэтгэмжийн даатгал	2,115,344.05	2,713,930.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,309,912.96	2,171,144.95
210204	Ажилгүйдлийн даатгал	338,718.70	522,964.99
210205	Эрүүл мэндийн даатгал	4,514,986.77	5,229,650.05
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,050,204.60	11,038,096.37
210301	Гэрэл, цахилгаан	2,795,203.00	3,233,856.92
210302	Түлш, халаалт	7,255,001.60	7,804,239.45
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,934,480.00	73,363,130.00
210401	Бичиг хэрэг	2,387,940.00	4,330,545.00
210402	Тээвэр, шатахуун	9,160,000.00	13,860,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,050,950.00	1,083,170.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,820,190.00	30,871,679.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	21,487,336.00
210408	Бараа материал акталсны зардал	1,515,400.00	1,730,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	30,123,104.00	81,570,859.06
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,788,988.00	68,698,666.00
210502	Хоол, хүнс	3,994,116.00	10,735,693.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,340,000.00	2,136,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,530,630.00	6,569,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,109,630.00	2,640,150.00
210604	Урсгал засвар	4,421,000.00	3,928,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	749,000.00	92,000.00
210702	Дотоод албан томилолт	749,000.00	92,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,934,150.00	2,960,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,934,150.00	2,960,550.00

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,010,093.48	19,419,634.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,455,575.00	785,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,554,518.48	18,633,884.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,588,956.18	30,583,313.18
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,416,906.00	29,524,350.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,416,906.00	29,524,350.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	25,172,050.18	1,058,963.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,172,050.18	1,058,963.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>6,386,714.52</b>	<b>219,848,804.35</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>6,386,714.52</b>	<b>219,848,804.35</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	285,892,103.87	155,744,564.19	-78,963,834.42	00.00	362,672,833.64
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>285,892,103.87</b>	<b>155,744,564.19</b>	<b>-78,963,834.42</b>	<b>00.00</b>	362,672,833.64
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,436,349.78	00.00	25,436,349.78
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>285,892,103.87</b>	<b>155,744,564.19</b>	<b>-82,442,953.12</b>	<b>00.00</b>	359,193,714.94
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>285,892,103.87</b>	<b>155,744,564.19</b>	<b>-82,442,953.12</b>	<b>00.00</b>	359,193,714.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>285,892,103.87</b>	<b>155,744,564.19</b>	<b>-82,442,953.12</b>	<b>00.00</b>	359,193,714.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	219,848,804.35	00.00	219,848,804.35
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>285,892,103.87</b>	<b>155,744,564.19</b>	<b>137,405,851.23</b>	<b>00.00</b>	579,042,519.29

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>183,347,410.00</b>	<b>625,799,446.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>450,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	450,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	450,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	450,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>183,347,410.00</b>	<b>625,349,446.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	168,778,100.00	361,338,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	68,400.00	234,177,124.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	233,337,124.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	68,400.00	840,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	6,044,800.00	17,370,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	6,044,800.00	17,370,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	8,456,110.00	12,464,022.00

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,456,110.00	12,464,022.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>163,396,697.00</b>	<b>550,716,819.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>163,396,697.00</b>	<b>550,716,819.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>162,545,997.00</b>	<b>520,158,506.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>117,156,413.00</b>	<b>331,402,245.41</b>
210101	Үндсэн цалин	76,186,153.00	227,048,962.56
210102	Нэмэгдэл	31,093,938.00	73,961,780.62
210104	Урамшуулал	9,876,322.00	30,391,502.23
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,735,800.00</b>	<b>36,004,681.32</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,770,000.00	25,366,990.35
210202	Тэтгэмжийн даатгал	996,100.00	2,713,930.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	800,800.00	2,171,144.95
210204	Ажилгүйдлийн даатгал	162,300.00	522,964.99
210205	Эрүүл мэндийн даатгал	2,006,600.00	5,229,650.05
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,967,604.00</b>	<b>11,311,336.82</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,676,040.00	3,233,856.92
210302	Түлш, халаалт	3,291,564.00	8,077,479.90
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,649,655.00</b>	<b>48,211,320.00</b>
210401	Бичиг хэрэг	1,449,305.00	3,845,420.00
210402	Тээвэр, шатахуун	4,628,500.00	13,860,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	665,950.00	1,083,170.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	905,900.00	29,199,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	222,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>10,515,800.00</b>	<b>82,827,123.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,379,130.00	70,026,458.00
210502	Хоол, хүнс	1,266,670.00	11,800,665.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	870,000.00	1,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,257,600.00</b>	<b>6,563,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	971,600.00	1,222,500.00
210602	Тавилга	00.00	1,231,000.00
210604	Урсгал засвар	286,000.00	4,110,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>549,000.00</b>	<b>92,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	549,000.00	92,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,415,950.00</b>	<b>2,960,550.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,415,950.00	2,960,550.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>298,175.00</b>	<b>785,750.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	298,175.00	785,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>850,700.00</b>	<b>30,558,313.18</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>850,700.00</b>	<b>29,499,350.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	850,700.00	29,499,350.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,058,963.18</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,058,963.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>19,950,713.00</b>	<b>75,082,626.27</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>36,458,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>36,458,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>36,458,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	36,458,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-36,458,500.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>19,950,713.00</b>	<b>38,624,126.27</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>19,950,713.00</b>	<b>38,624,126.27</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	397,475,700.00	378,347,653.43
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	397,475,700.00	378,347,653.43
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	391,475,700.00	375,048,303.43
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	285,624,800.00	272,920,817.29
210101	Үндсэн цалин	175,239,700.00	168,567,534.44
210102	Нэмэгдэл	81,541,200.00	73,961,780.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,788,000.00	00.00
210104	Урамшуулал	24,055,900.00	30,391,502.23
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,906,700.00	36,004,681.32
210201	Тэтгэврийн даатгал	27,378,900.00	25,366,990.35
210202	Тэтгэмжийн даатгал	2,882,000.00	2,713,930.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,305,400.00	2,171,144.95
210204	Ажилгүйдлийн даатгал	576,400.00	522,964.99
210205	Эрүүл мэндийн даатгал	5,764,000.00	5,229,650.05
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,370,300.00	11,311,336.82
210301	Гэрэл, цахилгаан	3,370,300.00	3,233,856.92
210302	Түлш, халаалт	9,000,000.00	8,077,479.90
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,633,900.00	17,525,210.00
210401	Бичиг хэрэг	3,099,900.00	3,099,290.00
210402	Тээвэр, шатахуун	11,500,000.00	11,701,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000.00	1,083,170.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,634,000.00	1,641,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	24,040,000.00	26,005,458.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,960,000.00	21,602,815.00
210502	Хоол, хүнс	4,080,000.00	3,402,643.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,500,000.00	7,442,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	442,500.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	400,000.00	92,000.00
210702	Дотоод албан томилолт	400,000.00	92,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,000,000.00	2,960,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	2,960,550.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2000000.00	785750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	785,750.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6000000.00	3299350.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,000,000.00	3,299,350.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	3,299,350.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	397,475,700.00	390,563,358.82
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	361,338,000.00	361,338,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	361,338,000.00	361,338,000.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	17,370,300.00	16,311,336.82
132001	Орон нутгийн төсвөөс	17,370,300.00	16,311,336.82

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	18,767,400.00	12,464,022.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,767,400.00	12,464,022.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>207,768,703.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>207,768,703.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	181,568,703.12
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	58,481,428.12
210101	Үндсэн цалин	58,481,428.12
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,355,610.00
210401	Бичиг хэрэг	746,130.00
210402	Тээвэр, шатахуун	2,158,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,558,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,892,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	56,821,665.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,423,643.00
210502	Хоол, хүнс	8,398,022.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,910,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,910,000.00
210602	Тавилга	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	26200000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,200,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	234177124.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	234,177,124.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	233,337,124.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	840,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

**3. Аудитын тайлан**

**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц

бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Халзан сумын Эрүүл мэндийн төв нь “Хүн амд эмнэлгийн тусламжийг жигд хүртээмжтэй, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг эрхэмлэнэ” гэсэн зорилгын хүрээнд мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж, бүсийн сум дундын эмнэлэг болох зорилт дэвшүүлэн үйл ажиллагаандаа 593.0 сая төгрөгийг зарцуулан ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Халзан сумын Эрүүл мэндийн төвд тайлант хугацаанд Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан шалгалтын бүрэлдэхүүн ковид-19 цар тахалтай холбоотой шалгалт хийж, мэргэжил арга зүйгээр зөвлөн тусалжээ. Мөн Санхүүгийн хяналт аудитын албаны төлөвлөгөөт шалгалтыг 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдэж зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 389.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.8 сая, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 219.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52.9	217.1	164.2
<b>Мөнгөн хөрөнгө</b>	0.00	38.6	38.6
<b>Төрийн сангийн харилцах</b>			
<b>Нэмэлт санхүүжилтийн харилцах</b>	0.00	38.6	38.6
<b>Авлага</b>	0.4	117.7	117.3
<b>Бусад авлага</b>	0.4	117.7	117.3
<b>Бараа материал</b>	52.4	60.7	8.3
<b>Үндсэн хөрөнгө</b>	306.3	353.9	55.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>359.2</b>	<b>579.0</b>	<b>219.8</b>
<b>Өр төлбөр</b>	0.00	0.00	0.00
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	359.2	579.0	219.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>359.2</b>	<b>579.0</b>	<b>219.8</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 60.7 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 0.3 сая барилгын завсрын материал 20.6 сая, хүнсний материал 0.9 сая, бусад хангамжийн материал 1.2 сая, нийт 23.0 сая төгрөгөөр үлдэгдэл өссөн, эм боох материал 4.4 сая, тусгай зориулалтын материал 6.3 сая, сэлбэг хэрэгсэл 4.0 сая нийт 14.7 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 521.6 сая төгрөг болж 74.3 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн газраас эмнэлгийн зориулалттай тоног төхөөрөмж 32.6 сая, тавилга 5.1 сая, нийт 37.7 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн бөгөөд төсвийн

хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга 36.4 сая нийт 74.3 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 18.6 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 117.3 сая төгрөг болж өссөн нь Эрүүл мэндийн сайдын А/337-99 тоот тушаалын дагуу ковид-19 цар тахлаар өвчлөн хэвтэн эмчлүүлсэн иргэний төлбөр эрүүл мэндийн даатгалаас олгоогүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 579.4 сая төгрөг болж 219.8 сая төгрөгөөр өссөн байна.

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 416.9 сая төгрөгөөр буюу 105.2 хувиар өссөн нь улсын төсвөөс санхүүжих 23.7 сая, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 339.7 сая, орон нутгийн санхүүжилт 3.1 сая нийт 366.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, бөгөөд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 52.5 сая төгрөгөөр нэмэгджээ. ЭМД-ийн санхүүжилт 2.2 сая төгрөгөөр буурсан тус тус нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 187.1 сая төгрөг буюу 40.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид-19 цар тахалтай холбоотой цалин, НДШ, эмийн зардал, ариутгал халдваржуултал, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмжийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 397.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 397.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 397.4 сая төгрөгийн төсөв баталснаас 361.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 17.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжих, 18.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 361.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 12.4 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 0.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 378.3 сая төгрөгийг зарцуулж, 12.2 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ковид-19 цар тахалтай холбоотой хэвтэн эмчлүүлэгчийн ор хоногийн санхүүжилт, дархлаажуулалт вакцины санхүүжилт, эмнэлгийн албан хаагч нарт нэг удаагийн тэтгэмжид 233.3 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.8 сая, нийт 234.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс 58.5 сая, Ковид-19 цар тахалтай холбоотой эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, тээвэр шатахуун, хоол хүнс 118.6 сая, тоног төхөөрөмж 33.9 нэг удаагийн тэтгэмжийн зардалд 26.2 сая, нийт 207.7 сая төгрөгийг зарцуулжээ. 26.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал үүсээгүй бөгөөд Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эд хариуцагч нарт “албан тушаалын тодорхойлолт”-д тусгасан албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргийг гүйцэтгүүлж сумын төвийн дуудлагын багасах, бараа материалын тайланг хуулийн хугацаанд гаргуулах.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Халзан сумын 2021 оны санхүүгийн тайланд эрүүл мэндийн даатгалын сангаас 117.7 сая төгрөгийн авлагатай, иргэн, хуулийн этгээдэд богино хугацаат өр төлбөргүй байна. Уг авлагыг 2022 оны 01 сард бүрэн олгосон бөгөөд 2021 оны төсвийн үлдэгдэл 38.6 сая төгрөг байна. Төсвийн үлдэгдлийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг баримтлан, дээд шатны төсвийн захирагч болон төсөв батлах эрх бүхий байгууллагын шийдвэрээр зарцуулах эрх олгох эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй байна. Мөн түргэвчилсэн шинжилгээний оношлуур худалдан авч иргэдэд үнэ төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн ч харилцах дансаар орлогыг тушаагүй санхүүгийн тайланд илэрхийлэхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 3, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд байршуулжээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, зөвлөмж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Халзан сумын Эрүүл мэндийн төвийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд төлбөртэй шинжилгээний орлогыг байгууллагын харилцах дансаар бүртгэж тайлагнасан эсэх.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 81.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12.4 сая төлбөрийн акт тогтоож, 69.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, асуудалд 3 зөвлөмж өглөө.

### **4.1 Төлбөрийн акт**

4.1.1 Коронавирус халдварын шинжилгээний төлбөр 9,8 сая төгрөгийг харилцах дансанд тушаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1

/төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/,<sup>16</sup> дугаар зүйлийн 16.5.5. /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх /, 20 дугаар зүйлийн 20.2.4./нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах / дахь заалт, сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалтай заалттай нийцэхгүй байна.

4.1.2 Хоолны зардлаас хэмнэгдсэн, төсвийн хэмнэлтэд тооцогдохгүй төсвийн үлдэгдэл 2.5 сая төгрөгийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, хүнсний материал нөөцөлсөн алдаа зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 /Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ./, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, 45 дугаар зүйлийн 45.2 /Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ/ дахь заалттай нийцэхгүй байна.

## 4.2 АЛБАН ШААРДЛАГА

4.2.1 Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1<sup>1</sup>, 72.4.2<sup>2</sup>, 72.4.4<sup>3</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6<sup>4</sup> дахь заалт болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Бараа материалын тайланд 68.0 сая төгрөгийн эмийг нэг бүрийн үнэ, тоо хэмжээ, өртгөөр орлого авч тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 /санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 /аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх;/, 20 дугаар зүйлийн 20.2.4 /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/, Сангийн сайдын 388 тоот тушаал болон ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.3 Эмч, эмнэлгийн ажилтан нарын илүү цагийн хөлсийг дуудлага дуудсан газрын нэр, өвчтөний оношийг дутуу бичсэн баримтаар олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 /аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх;/, 20 дугаар зүйлийн 20.2.4 /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4 дахь заалт, Сангийн сайдын 388 тоот тушаал болон иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.4 Илүү цагаар ажилласан тухай бүртгэл хөтлөхгүй сар бүр 25 цаг илүү ажилласнаар тооцож жолоочид 1,509.8 мянган төгрөгийг олгожээ. Энэ нь Нягтлан бодох

<sup>1</sup> эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

<sup>2</sup> тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

<sup>3</sup> комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

<sup>4</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 /аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх;/, 20 дугаар зүйлийн 20.2.4 /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;/заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.4 дахь заалт, Сангийн сайдын 388 тоот тушаал болон иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.3.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

###### 4.3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 103 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

###### 4.3.1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

##### 4.3.2. Шилэн данстай холбоотой асуудал

###### 4.3.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс 7 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

4.3.2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халзан сумын Эрүүл мэндийн төв	9	81.9	-	-	2	12.4	4	69.5	3	-

/сая төгрөгөөр/

